ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Есдүгээр цэцэрлэгийн 2023 оны хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2024/171/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Хэнтий аймаг<br>Чингис хот<br>2024 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар<br>Утас: 70562112<br>Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Оюунтуяа<br>Утас: 99775390<br>Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Их наяд аудит ХХК-ийн<br>Захирал: Х.Ариунзул<br>Утас: 11-450410<br>Цахим хаяг: ikhnayadaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn


2024-03-11 № 276

танай ______________ -ны № ______________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
ЕСДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ОЮУНГЭРЭЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Есдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Есдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Хэнтий аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас 26,582.2 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 4,750 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авсан ба машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын дансанд хүлээн авч, хууль, журмын дагуу бүртгэл тайланд тусгасан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

### Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж

хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд болон хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургуулийн өмнөх боловсрол олгох 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, 2023 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн төсвийг 85.4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **142,595,484.71** | **272,013,941.71** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **2,217,832.21** | **123,114,709.21** |
| **31200** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **2,217,832.21** | **123,114,709.21** |
| **31210** | **Төгрөг** | **2,217,832.21** | **123,114,709.21** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **140,377,652.50** | **148,899,232.50** |
| **35100** | **Түүхий эд материал** | **747,798.00** | **754,700.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | - |
| 35130 | Эм боох материал | 747,798.00 | 754,700.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **139,629,854.50** | **148,144,532.50** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,377,198.00 | 2,905,098.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,084,680.00 | 905,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 29,824,390.00 | 1,911,450.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,207,830.00 | 10,183,908.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 104,135,756.50 | 132,239,076.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,060,680,644.83** | **2,039,237,175.31** |
| 37330 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | - | - |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,060,680,644.83** | **2,039,237,175.31** |
| 39100 | Газар | - | - |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,969,463,144.74** | **1,948,269,675.18** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,970,158,000.00 | 1,970,158,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (76,617,255.68) | (109,453,222.40) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 71,946,758.21 | 98,528,978.21 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (19,013,580.40) | (30,885,373.48) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 36,968,445.25 | 41,718,445.25 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (13,979,222.64) | (21,797,152.40) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **91,217,500.09** | **90,967,500.13** |
| 39301 | Программ хангамж | 1,250,000.00 | 1,250,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (562,499.91) | (812,499.87) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 90,530,000.00 | 90,530,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,203,276,129.54** | **2,311,251,117.02** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,203,276,129.54** | **2,311,251,117.02** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,203,276,129.54** | **2,311,251,117.02** |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **2,112,746,129.54** | **2,220,721,117.02** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -90,675,398.92 | 2,112,746,129.54 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 2,203,421,528.46 | 107,974,987.48 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 90,530,000.00 | 90,530,000.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,203,276,129.54** | **2,311,251,117.02** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 2,839,058,609.40 | **888,380,120.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 2,253,588,309.40 | **48,532,220.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,253,588,309.40 | **48,532,220.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **103,500.00** | **-** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 103,500.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 2,110,309,466.90 | 31,332,220.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 143,175,342.50 | 17,200,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **585,470,300.00** | **839,847,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **475,264,000.00** | **757,505,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 475,264,000.00 | 757,505,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **110,206,300.00** | **82,342,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 110,206,300.00 | 82,342,800.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **635,637,080.94** | **780,405,132.52** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **635,637,080.94** | **780,405,132.52** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **624,910,836.80** | **771,298,150.37** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **364,139,480.85** | **448,617,629.00** |
| 210101 | Үндсэн цалин | 321,970,864.46 | 406,880,692.00 |
| 210102 | Нэмэгдэл | 37,478,866.39 | 39,345,981.00 |
| 210104 | Урамшуулал | 4,689,750.00 | 2,390,956.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **46,573,388.98** | **59,297,491.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,817,904.95 | 41,226,675.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,730,988.20 | 4,884,687.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,936,641.51 | 3,589,601.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 717,939.63 | 860,642.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,369,914.69 | 8,735,886.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **71,458,370.90** | **69,878,912.85** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,757,635.90 | 9,573,645.85 |
| 210302 | Түлш, халаалт | 60,182,761.00 | 53,810,116.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,517,974.00 | 6,495,151.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,620,920.00** | **-** |
| 210401 | Бичиг хэрэг | 610,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,010,920.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **68,844,769.00** | **82,746,240.00** |
| 210502 | Хоол, хүнс | 68,844,769.00 | 82,746,240.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,736,550.00** | **376,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 3,736,550.00 | 376,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,516,200.00** | **8,439,745.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 7,522,845.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,516,200.00 | 916,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **67,021,157.07** | **101,942,132.52** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,066,785.00 | 49,166,443.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,797,600.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 52,156,772.07 | 52,775,689.52 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,726,244.14** | **9,106,982.15** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **9,097,690.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 9,097,690.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **10,726,244.14** | **9,292.15** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,726,244.14 | 9,292.15 |
| 213404 | Хөрөнгийн зардал | - | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | 2,203,421,528.46 | **107,974,987.48** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | 2,203,421,528.46 | **107,974,987.48** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **585,573,800.00** | **839,847,900.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **103,500.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **103,500.00** | **-** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **103,500.00** | **-** |
| 120004 2 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 103,500.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **110,206,300.00** | **82,342,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 110,206,300.00 | 82,342,800.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **583,355,967.79** | **718,951,023.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **583,355,967.79** | **718,951,023.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **572,629,723.65** | **709,844,040.85** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **365,499,572.10** | **448,617,629.00** |
| 210101 | Үндсэн цалин | 296,788,442.71 | 293,254,472.00 |
| 210102 | Нэмэгдэл | 61,937,928.39 | 141,152,549.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | - |
| 210104 | Урамшуулал | 6,773,201.00 | 14,210,608.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **46,468,376.65** | **59,297,491.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,781,633.89 | 41,177,941.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,712,799.20 | 4,853,943.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,922,100.82 | 3,619,152.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 716,529.14 | 865,180.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,335,313.60 | 8,781,275.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **71,458,370.90** | **77,401,757.85** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,757,635.90 | 8,264,158.85 |
| 210302 | Түлш, халаалт | 60,182,761.00 | 61,484,904.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,517,974.00 | 7,652,695.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **644,070.00** | **-** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 644,070.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **66,754,584.00** | **92,478,488.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | - |
| 210502 | Хоол, хүнс | 66,754,584.00 | 92,478,488.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,685,200.00** | **4,931,750.00** |
| 210604 | Урсгал засвар | 3,685,200.00 | 4,931,750.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | **-** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,254,200.00** | **1,399,000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,254,200.00 | 1,399,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **16,865,350.00** | **25,717,925.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,865,450.00 | 21,518,925.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,999,900.00 | 4,199,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,726,244.14** | **9,106,982.15** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **9,097,690.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 9,097,690.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **10,726,244.14** | **9,292.15** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,726,244.14 | 9,292.15 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **2,217,832.21** | **120,896,877.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **2,217,832.21** | **120,896,877.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 2,217,832.21 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,217,832.21 | 123,114,709.21 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | - | - |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | - | 90,530,000.00 | (90,675,398.92) | (145,398.92) |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | 90,530,000.00 | (90,675,398.92) | (145,398.92) |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | - | - | 2,203,421,528.46 | 2,203,421,528.46 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | 90,530,000.00 | 2,112,746,129.54 | 2,203,276,129.54 |
| 11 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | - | 90,530,000.00 | 2,112,746,129.54 | 2,203,276,129.54 |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | 90,530,000.00 | 2,112,746,129.54 | 2,203,276,129.54 |
| 19 | **Тайлант үеийн үр дүн** | - | - | 107,974,987.48 | 107,974,987.48 |
| 20 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | 90,530,000.00 | 2,220,721,117.02 | 2,311,251,117.02 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **842,065,700.00** | **718,941,730.85** | **123,123,969.15** | **85.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **842,065,700.00** | **718,941,730.85** | **123,123,969.15** | **85.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **832,968,000.00** | **709,844,040.85** | **123,123,959.15** | **85.2** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **558,202,700.00** | **448,617,629.00** | **109,585,071.00** | **80.4** |
| 210101 | Үндсэн цалин | 369,555,600.00 | 293,254,472.00 | 76,301,128.00 | 79.4 |
| 210102 | Нэмэгдэл | 173,735,600.00 | 141,152,549.00 | 32,583,051.00 | 81.2 |
| 210104 | Урамшуулал | 14,911,500.00 | 14,210,608.00 | 700,892.00 | 95.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **70,125,100.00** | **59,297,491.00** | 10,827,609.00 | 84.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,797,200.00 | 41,177,941.00 | 6,619,259.00 | 86.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,582,100.00 | 4,853,943.00 | 728,157.00 | 87.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,465,600.00 | 3,619,152.00 | 846,448.00 | 81.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,116,400.00 | 865,180.00 | 251,220.00 | 77.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,163,800.00 | 8,781,275.00 | 2,382,525.00 | 78.7 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **77,410,500.00** | **77,401,757.85** | 4,941,042.15 | 94.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,265,000 | 8,264,158.85 | 841.15 | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 61,492,800 | 61,484,904.00 | 7,896.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,652,700 | 7,652,695.00 | 5.00 | 100.0 |
| | Урсгал | 4,932,300 | 4,931,750 | 550.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **95,171,200.00** | **92,478,488.00** | 2,692,712.00 | 97.2 |
| 210502 | Хоол, хүнс | 95,171,200.00 | 92,478,488.00 | 2,692,712.00 | 97.2 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,932,300 | **4,931,750.00** | 550.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 4,932,300 | 4,931,750.00 | 550.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,399,700.00** | **1,399,000.00** | 700.00 | 99.9 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,399,700.00 | 1,399,000.00 | 700.00 | 99.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **25,726,500.00** | **25,717,925.00** | 8,575.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,527,500.00 | 21,518,925.00 | 8,575.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,199,000.00 | 4,199,000.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,097,700.00** | **9,097,690.00** | 10.00 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **9,097,700.00** | **9,097,690.00** | 10.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,097,700.00 | 9,097,690.00 | 10.00 | 100.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **842,065,700.00** | **839,838,607.85** | 2,227,092.15 | 99.7 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **757,505,100.00** | **757,505,100.00** | - | 100.0 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 757,505,100.00 | 757,505,100.00 | - | 100.0 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **82,342,800.00** | 82,333,507.85 | 9,292.15 | 99.9 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **2,217,800.00** | **-** | 2,217,800.00 | 0.0 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 2,217,800.00 | - | 2,217,800.00 | 0.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 2,217,832.21 | (2,217,832.21) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 123,114,709.21 | (123,114,709.21) | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | **-** | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **32** | **32** | **-** | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | **-** | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16 | 16 | **-** | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 14 | 14 | **-** | 100.0 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **253** | **253** | **-** | 100.0 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | **253** | **253** | **-** | 100.0 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 1 | 1 | | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **31** | **0** | **31** | 0 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 17 | 17 | **-** | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 14 | 14 | **-** | 100.0 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 68,667.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 68,667.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд орлого, зарлагын нийт 6 гүйлгээний 68,667.6 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна. | 1 | 68,667.6 | | | | | 1 | 68,667.6 |
| **Дүн** | **1** | **68,667.6** | | | | | **1** | **68,667.6** |